

**МОНГОЛ ИДЭЭ УНДААНЫ СОЁЛ ДАХЬ
АРИУН БА БУЗРЫН ОЙЛГОЛТ**

Г. Нандинбилиг*

Монголчууд аливаа идээ ундаанд нүдэнд үл үзэгдэх бузар болоод ариун чанар оршино хэмээн үздэг. Энэ нь бүх орчлонг нүдэнд үзэгдэх ба нүдэнд үл үзэгдэх хоёр тал болгон ухаарах эртний домын сэтгэлгээнээс үүдэлтэй. Иймээс монгол идээ ундааны соёл дахь ариун ба бузрын ойлголтыг судлахын тулд монголчуудын ан агнуурын соёлоос эхлээд мал аж ахуйн соёлын хүрээнд уламжилж ирсэн улаан идээ буюу мах шүүсний талаарх арвин цээрээс өнөөг хүртэл уламжилж ирсэн хамгийн түгээмэл цөөн жишээг сонгон, домог зүйн үндэстэй нь харьцуулан, задлан шинжлэхийг зорисон болно.

Монголчуудын идээ ундааны соёл дахь ариун ба бузрын ойлголтыг шинжлэхийн тулд ариун бузрын талаарх онолын ойлголт болоод монгол угсаатны ариун бузрын талаарх ерөнхий ойлголтыг судлан шинжилсэн судалгааны ололтыг бүртгэн үзэх нь зүй юм. Ариун ба бузрыг ялгах соёлын судалгааны асуудал бол Э.Тайлор, Ж.Фрейзер, Э.Дүркхайм, М.Дуглас нарын судалгаатай салшгүй холбоотой. Францын антропологич Э.Дүркхайм бээр энэ ойлголтыг тотем буюу сүлд шүтлэгийн талаас авч үзээд, 1968 онд “Шашны амьдралын анхдагч хэлбэрүүд”¹ номдоо “...дэлхий дээр ариун эсвэл бузар зүйл гэж ерөөс байхгүй бөгөөд хүмүүс овгоороо бүлгээрээ нийлж л ямар нэгэн зүйлийг ариун эсвэл бузар хэмээн шийдсэний үндсэн дээр ямар нэгэн зүйл ариун эсвэл бузар болж тодорхойлогддог байна (Durkheim 1968: 165-173) гэж үзсэн бол ариун бузрын ойлголтыг хүн судлалын ухааны нэгэн гол сэдэв болгон хөгжүүлсэн Их Британийн хүн судлаач М.Дуглас бээр Зайрийн Лелечүүдийн бохир бузраас цэрвэн сэжиглэх сэтгэлгээ хийгээд “Хуучин Гэрээнд” заасан эртний Еврей нарын гэгээрэлд хүрэх зам мөрийг заан сургасан цээр ёсны идэж болох, болохгүй зүйлсийн жишээг судлаад, 1966 онд “Ариун ба аюул”² хэмээх бүтээлдээ “энэ бол эрүүл ахуйн тухай асуудал огт биш бөгөөд харин ч бэлгэдэн ангилах тогтолцоо юм” (Douglas 1966: 51-71) гэж дүгнэсэн байдаг.

Аливаа угсаатны соёл дахь ариун бузрын утга учрыг ойлгохын тулд тэдний эртний домог зүйн сэтгэлгээний өвөрмөц онцлогийг мэдэх хэрэгтэй. Хүний үүслийн монгол домгийн халх хувилбарын тухайд өгүүлэмжийнх нь гол оньс гэвэл Бурхан хүнийг бүтээх гэж шавраар эр, эм хоёр хүний дүрс хийгээд амь оруулах гэж мөнхийн рашаанд

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим

¹) Durkheim E. (1968). The Elementary Forms of Religious Life. J. Swain. trans. New York: Free Press.

²) Douglas Mary. (1966). Purity and Danger: An Analysis of concepts of pollution and taboo. Routledge.

явах болжээ гэж гардаг. Домогт цааш өгүүлэхдээ “...*Явсан хойгуур чөтгөр хорлох магадгүй гэж нохой, муур хоёроор өнөөх хоёр шавар хүнийг сахиулдаг юм байж. “Та хоёр, энэ хоёр хүнийг сайн харж бай! Намайг мөнхийн рашаан авчиртал амьтан бүү хавьтуул! Энэ хоёр, та хоёрын эзэн болж ивээх тул хичээж сайн харж сахиж бай! гэжээ. Тэгээд Бурханы явсан хойгуур Чөтгөр, Бурханы туурвилыг хорлох гэж иртэл нохой муур хоёр нь хавьтуулахгүй байжээ.Тэгэхлээр нь чөтгөр, мууранд сүү, нохойд мах авчирч өгөөд идэж байх хооронд нь хоёр шавар хүн рүү эргэн тойрон шээж бузарлаад яваад өгч гэнэ.Бурхан мөнхийн рашаан авчирч хоёр хүнийг амь оруулах гэтэл үс нь бузартсан байсанд бурхан хилэгнэж, муурыг “хүний энэ үсийг зулба долоогоод арилга” гэв.Муураар зулба долоолгож цэвэрлүүлсэнд гагцхүү толгойн үсэнд чөтгөрийн шээс хүрсэнгүй тулд үлдээлгэж, мөн суга цавинд муурын хэл хүрээгүй газарт бага сага бузар үс үлдэж гэнэ.Чөтгөр шээсэн бузар үсийг нохойд тохож гэсгээн цээрлүүлсэн гэнэ.Иймээс хүн нүцгэн болж, нохой үстэй болсон гэнэ.Мөн үүний шалтгаанаар муурын хэл бузар, нохойн үс бузар гэж хэлэлцдэг ба хүн чөтгөрийн хорлолоор бузартсан учир Бурхан хүний аманд мөнхийн рашаан дусаасан боловч хүн мөнх наслахгүй зуурдаар үхдэг болов [Гаадамба, Цэрэнсодном 1978, 139-140] гэж гардаг.Монгол домог зүйг судалсан эрдэмтэн С.Дулам бээр тус домгийг бүтэц зүйн аргаар задлан шинжлээд “*Бурхан-Чөтгөр* гэсэн хос туурвигч, түүнээс иш үндэстэй *Хүн-Нохой* гэсэн хоёр төрөлхтөн, *Рашаан-Шээс* гэсэн хоёр үүтгэлээс үндэстэй *Цэвэр-Бузар* гэсэн хоёр чанар, *Нүцгэн-Үстэй* гэсэн бүтээл туурвилын хоёр үр дүн гарч ирж байна. *Бурхан, Чөтгөр* хоёр анхнаасаа заяамал /өгөгдсөн/ эсрэг тэсрэг хоёр туурвигч мөн бөгөөд эл хоёрын сөрөгцлөөс бусад бүх хосмолжин эсрэгцлүүд (*opposition binaire*) үүдэн гарч байна” хэмээгээд “монгол домог зүйн далд гүн ухааны ёсоор аливаа бүтээл туурвил болгон бурханлаг чанартай, цэвэр ариун байдаг бол бүтээл туурвилыг хорлон бусниулагч болгон чөтгөрлөг шинжтэй, бузар булай юм байдаг. *Нүцгэн-Үстэй* гэсэн хосмолжин бол бүтээл туурвилын үр дүн бөгөөд угтаа *Хүн-Амьтан* гэсэн хоёр төрөлхтний заяамал шинж болж, өөрийн учир зүйн дагуу *Цэвэр- Бузар* хоёрт аяндаа хамаатаж очно... Энэ бол монгол домог зүйн чанадад буй уг үлгэр болно” (Дулам С. 2009: 2004) хэмээн судлан тогтоосон байдаг нь бидний судалгаанд суурь ач холбогдлыг бүрдүүлж байна.*

Монголчуудын мах шүүс идээний соёлыг авч үзвэл ерөнхийдөө монгол домог зүйн гурван ертөнцийн төрөлхтнөөс дээд тэнгэрийн жигүүртэн шувуу, доод лусын хайрстан загас могойн махыг цээрлэж, энэ ертөнцийн мөчтөн амьтнаас арслан, бар, чоно зэрэг махчин амьтны мах болон үнэг, хярс, элбэнх зэрэг бар тавагтай мануулын төрлийн амьтны махыг идэхийг хатуу цээрлэхийн зэрэгцээ биебодын заримдаг шинжтэй, хоёр нутагтан амьтны махыг идэхийг цээрлэж иржээ. Тодруулж хэлбэл, өвсөн тэжээлтэй мөчтөн амьтны мах, тэр дундаа эвэртэн туруутан амьтны махыг идэхэд цээргүй, харин араатан амьтны мах болон махан тэжээлт жигүүртэн хайрстны махыг идэхийг цээрлэдэг байна. Тэнгэрийн жигүүртэн болоод усны загас могой зэрэг хайрстан амьтдыг алж агнавал “*тэнгэр лус хилэгнэнэ*” хэмээх үзэл нийдэм бөгөөд энэ нь жигүүртэн хайрстны мах шүүсийг хүнсэнд нэмэр арви багатай учраас тэнгэр лусаар аюулгах аргаар байгаль хамгаалж ирсэн тэргүүн туршлага болохыг бид мэднэ.

Хүн яагаад махан хүнстэн болсон тухайд эртний домогт өгүүлэхдээ“*Хүн анх эхлээд өвс ногоо иддэг байжээ. Бурхан багш хүнийг аль хэр өвс ногоо иддэг юм, үзье гэж санаад унагатай гүү, хүүхэдтэй хүүхэн хоёрыг нэг нэг өвстэй жалганд ойрхон идээшлүүлж тавьжээ. Үдийн хугас бололгүй эргэж ирээд үзвэл хүүхэдтэй хүүхэн нь өөрийнхөө оноосон жалганы өвсийг идэж эхэлмэгц тэр хоёр муудалцаж Бурхан багишид*

зарга мэдүүлж гэнэ. Бурхан багш энэ заргыг шүүгээд, “ер нь хүн өвс ногоо идэж, зохихгүй юм байна, хүнийг хэмжээтэй мах шүүстэй хоолонд оруулъя” гэж хэргийг шийтгэсэн юм³ гэх ба эрдэмтэн С.Дулам тус домгийн өгүүлэмжийг хам цагийн хүрээнд босоо бүтцээр /синхрония/, домогловоруудыг /мифема/ эн зэрэгцүүлэх /парадигматик/ аргаар авч үзээд, “шим ертөнцийн орчил доторхи амьтны аймаг нь өвс ургамлыг идэж, тэр амьтныг бусад араатан болон хүн идэж бие биеэ дараалан золиослох “үйлийн үртэй” гэдгийг гаргаж байна” (Дулам С. 2009: 215-216) хэмээн дүгнэсэн байдаг.

Монголчуудын ан агнуурын соёлын хүрээнд ангийн мах шүүстэй холбогдох олон зүйлийн цээр ёс уламжилж ирснээс баавгай, буга зэрэг тураг ангийн цээрийн тухайд эртний сүлд шүтлэгтэй шууд холбогдох боловч бугын махыг хүнсэнд хэрэглэхийг хориглосон зүйл байдаггүйг бид мэднэ. Харин борог ангийн цээрийн дотор хамгийн содон нэгэн цээр бол “тарваганы хүн махны цээр” бөгөөд үүнийг ямагт “тарвага урьд нь мэргэн харваач байсан” гэх юм уу “тарвага өмнө нь хүний мах иддэг байсан” гэх домгийн уран сэтгэмж дагалдаж байдаг. Тарваганы үүслийн тухай домогт өгүүлэхээр “Эрт цагт тарвага нум агсаж, хүн алж иддэг байжээ. Ингээд хүн амьтан алж хөнөөгөөд байхаар нь бурхан багш тарваганы нум сум харвадаг эрхий хурууг нь огтлоод, эгэм далыг нь эмтлээд ам тангаргыг нь аваад “Эр хүний ганзаганы хоол бол” гээд тавьсан юм гэнэ. ..Хүн тарвага алж өвчихдөө хүн яс гэж эгмийг нь, хүн мах гэж харьтан дээрх хэсэг ягаан махыг, хүн бөөр гэж хоёр бөөрний хажууд наалдсан жижиг махыг заавал ялгаж хаядаг заншилтай болсон гэнэ тарвага дээр үед хүн идэж байсан тул ийнхүү хүний биеийн зарим эрхтэн махнаас үлдэж хоцорсон учиртай гэнэ” (МАДҮ., 1989, 96) гэх буюу “Тарвага уг нь эрт урьд цагт мэргэн харваач хүн байж гэнэ, тэр нэгэн удаа мэргэн харвадагтаа эрдэж, хараацай шувууг харваж унагаж чадахгүй бол мориныхоо урьд хоёр хөлийг огтолж, өөрийнхөө эрхий хурууг авч, хар ус уухгүй, хагд өвс идэхгүй газар дор орно гэж ам тангараг өгчээ...” (МАДҮ., 1989, 96) гэх зэргээр домоглож байна. Энэхүү уран сэтгэмжийг батлах мэт ард олны дунд өдгөө хүртэл “тарваганы хүн мах”-ны цээр байсаар байгаа билээ. Тарваганы эрхтэн махыг ямар нэг байдлаар хүнтэй холбон тайлбарласан эдгээр домгийн уран сэтгэмжийг эрт нэгэн цагийн идэш тэжээлийн хомсдол, их өлсгөлөнгийн хатуу ширүүн нөхцөлд хүн хүнээ барьж идэх үзэгдэл гарч байсантай холбогдож болох эртний хүний айдсын ой дурсамжтай холбон тайлбарлаж болох юм. Эртний домог зүйн энэ өгүүлэмжийн цаана хүмүүн болоод хүмүүн бус аливаа махан хүнст төрөлхтний махыг идэхээс татгалзсан хүн төрөлхтний соёлын дэвшлийн ул мөр хадгалагдаж байх бөгөөд “тарваганы хүн махны цээр” нь хүний махаар хүнслэх үзэгдэл дахин гарахаас болгоомжлон, хойч үедээ сэрэмжлүүлэн сануулах зорилго бүхий нэгэн зүйл соёлын код гэж бид үзэж байна.

Харин монголчуудын мал аж ахуйн соёл сэтгэлгээний хүрээнд малын мах шүүс идээний соёлтой холбогдох цээрийг авч үзвэл хамгийн нийтлэг нь тэмээний махтай холбоотой цээр байна. Тухайлбал дээд монголчууд тэмээний мах идэхийг хүний мах идсэн адил бузар гэж үзэн ихэд цээрлэдэг байжээ. Халх монголчууд ч тэмээний махыг идэж амсахыг цээрлэхээс гадна “...тэмээний махыг тахил шүүс өргөхөд үл хэрэглэнэ. Учир нь хүйтэн хушуутай малын мах гэнэ” (Аман хууль, 2000, 84). Тэмээг хүйтэн хушуут мал хэмээн нэрлэхийн тухайт соёл судлалын үндэстэй тайлбар бол

³⁾ Энэ домгийг 1981 онд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ард Магсарын Мишигээс /73 настай, халх/ С.Дулам бичиж авчээ.

тэмээний махны сэрүүн чанарыг таньсан монголчуудын танин мэдэхүйн туршлагаар тайлбарлаж болно. Харин домог зүйгээс хайж үзвэл тэмээг мөн л Чөтгөр бүтээсэн учраар тайлсан байдаг ба улмаар тэмээний тухайд Бурхан анх амьтдыг бүтээхдээ тэмээний засааг мартсан гэх буюу тэмээ буганд эврээ, адуунд сүүлээ алдсан гэх, эсвэл арван хоёр зүйлийн амьтны шинжийг хадгалсан гэх зэрэг домгийн уран сэтгэмжүүдийг бүтээжээ. Амьтны үүслийн тухай монгол домогт өгүүлэхээр, *“Эрт цагт Бурхан багш амьтдыг бүтээхдээ үхрийн бөөр, тэмээний засаа хоёрыг мартчихжээ...Тэмээг засаагаа авах гэж ирэхэд нь мөн л үлдсэн жаахан засаагаа өгсөн чинь “Би ийм том биетэй амьтан, наадах чинь даанч жижигхэн юм” гээд голоод авсангүй гэнэ. Тэхлээр нь Бурхан уурлаад “Авбал ав, байвал бай” гээд хойноос нь шидчихсэн хоёр жижигхэн засаа ард нь очоод наалдчихаж гэнэ. Тэмээний засаа ардаа байдгийн учир энэ гэнэ”* (МАДҮ., 1989, 86). Энэхүү уран сэтгэмжийг батлах тэмээний махны цээрийн гол жишээ бол болон *“агталсан тэмээний төмсөгийг идэхийг цээрлэх, шувуу нохойд өгөхийг цээрлэх”* (Аман хууль, 2000,18) явдал болно. Үхрийн бөөр, тэмээний засааны тухай энэхүү уран сэтгэмжээр монголчууд Бурхны түгээлээс гээгдэж дутахын буюу дутуу дундын ёгтолмол бүтээсэн байна.

Домогт цааш өгүүлэхдээ тэмээг арван хоёр салаа сүрлэг сайхан эврээ буганд хууртан өгч, өтгөн сайхан сүүлээ моринд алдаж хоцроод, арван хоёр жилийг ахлах болзолд хулганатай мэлзээнд орж ялагдан үлдсэн зэргээр домоглож, энэхүү уран сэтгэмжээрээ тэмээг биебод сүрлэг их ч гэнэн цайлган, арга ухаан хомс ахуйн ёгтолмол дүр болгосон байна. Эдгээр домгийн уран сэтгэмжээс ургуулан бодвоос тэмээний махыг ихэд цээрлэхийн учир нь тэмээний эвэргүй болоод сүүлгүй төрх байдал буюу биебодын дутагдах шинжтэй холбоотой байна. Чухам үүний нөгөө талд монголчууд энэ ертөнцийн мөчит амьтдаас битүү болон ац туруут, өвсөн тэжээлт, хивэгч амьтны махыг, таван хушуу малаас эвэрт малын махыг идэхийг эрхэмлэх ёс түгээмэл байгаа зэргээс харьцуулан үзэхэд тэмээний махыг цээрлэхийн учир нь юуны өмнө тэмээний эвэр туруугүй энэ л төрхтэй шууд холбоотой сэтгэлгээ болохыг илтгэнэ.

Монгол домогт тэмээг арван хоёр жилийн амьтны шинжийг биедээ цогцолсон арван гурав дахь амьтан болгон үзүүлэх домгийн уран сэтгэмжийг задлан шинжилвээс тэмээний бие бодын хоёрдмол шинж буюу чухам *“хулгана чихтэй, үхэр гэдэстэй, бар тавагтай, туулай хамартай, луу биетэй, могой нүдтэй, морин дэлтэй, хонин ноостой, мичин бөхтэй, тахиа өрвөлөгтэй, нохой гуятай, гахай сүүлтэй”*(МАДҮ., 1989, 88) байдал төрх, тэр дундаа тэмээний *“бар тавагтай”* болоод *“туулайн \сэтэрхий\ уруултай”* байгаа нь тэмээний махыг цээрлэхийн нууцыг өөртөө хадгалж байна. Бидний таамаглалыг батлах нэгэн жишээ бол *“жирэмсэн эх тэмээний мах идвэл сэтэрхий уруултай хүүхэд төрнө”* хэмээх цээр юм. Сэтэрхий уруулын талаарх энэ уран сэтгэмж бол бидний бодлоор *“Зараа сэцэний домогт”* гардаг хүмүүний цус ойртолтын айдсын нэгэн адил, биебодын хоёрдмол шинжтэй үр удам, ургийн гажигтай хүүхэд төрөхөөс эмээх айдсаас үүдэлтэй байна. Цаашилбал тэмээ хэмээх амьтныг арван хоёр зүйлийн амьтны шинжтэй буюу биебодын нэгдмэл шинжгүй гэж үзэн тэмээний махыг идэхийг цээрлэх ёс нь эрт цагт болсон амьтны зүйлийн өөрчлөлтийн талаарх эртний хүний ой дурсамжийг хадгалж байна.

Мах шүүс идээний ариун бузрын талаарх монголчуудын үзэл ойлголтыг баримжаалахын тулд ан агнуурын соёлоос хамгийн түгээмэл тархсан цээр болох тарваганы *“хүн мах”*-ны цээрийг авч судлахад *“тарвага урьд нь хүний мах идэж байсан”* гэсэн домгийн уран сэтгэмжээр дамжуулан хүний мах иддэг амьтны махыг идэж

болохгүй гэж онцлон өгүүлж байсан бол мал аж ахуйн соёлоос тэмээний махны цээрийг төлөөлүүлэн авч үзэхэд хүмүүн болоод хүмүүн бусын төгс ялгааг илтгэх гол шинж болох эвэр туруу тэмээнд байхгүй байгаа нь тэмээний махыг цээрлэх гол шалтгаан болж байна. Үүнээс үзвэл мах шүүс идээний ариун бузрын талаарх монголчуудын ангиллын анхдагч шалгуур нь хүмүүн болоод хүмүүн бусын төгс ялгааг илтгэх гол шинж буюу эвэр туруугаар тодорхойлогдож байна. Цаашилбал монголчууд эвэр туруутай буюу өвсөн тэжээлт амьтны мах бол ариун чанартай тул идэхэд цээргүй, харин эвэр туруугүй буюу тавхай (таваг)-тай, хүн амьтны махаар хооллодог амьтны мах нь бузар тул идэх цээртэйгэсэн соёлын ангиллыг бүтээсэн байна. Энэ нь “Хуучин Гэрээнд заасан идэж болох, болохгүй зүйлсийн жишээг авч үзээд ертөнц дээрх амьтдаас бүтүү болон ац туурайтай хэвэгч бүх л амьтныг идэж болно, харин энэ хоёр шинжийг аль нэг нь үгүй бол идэж болохгүй жишээ нь тэмээ, учир нь тэмээ хэвдэг боловч туурайгүй гэж үздэг байна... (Бум-очир Д, Мөнх-эрдэнэ 2012,) гэсэн М.Дугласын тайлбарыг санагдуулж байна.

Идээ ундааны цээр ёс нь басхүү дан ганц эртний домог шүтлэгийн хамаатай ойлголт биш бөгөөд бидний бодлоор эрхлэх аж ахуй, соёлынхоо гол ололт дэвшлийг хадгалах чинад зорилготой шууд холбоотой соёл болно. Монгол идээ ундааны соёл дахь ариун бузрын тухай ойлголтын жишээ нь сэг зэмийн хор бузраас эхлээд махчин амьтны махыг цээрлэх, зарим мал амьтны махыг бузар хэмээн идэж амсахыг сэжиглэх, араатны ам шүд хүрсэн махыг цээрлэх, амьтантай нэг тогооноос хооллохыг цээрлэх, шүүс идээг түүхий шүүрхий идэхийг цээрлэх, малын хүн хээр хөдөө мах идэхийг цээрлэх, малын мах сүүг ангийн мах шүүстэй ойр тавихыг цээрлэх зэрэг олон зүйлээр тохиолдох боловч нарийвчлан ажиглавал ерөнхийдөө дараах хоёр зүйлийн ялгаа тод ажиглагдаж байна.

1. Аливаа хүмүүн ба хүмүүн бус төрөлхтний махыг идэж байсан зэрлэг үеийг халж, зөвхөн өвсөн тэжээлт амьтныг агнаж хүнсэнд хэрэглэх болсон ан агнуурын соёлын дэвшлийн ул мөр

2. Байгалийн зэрлэг ан амьтныг авлаж агнан махыг нь хүнсэндээ хэрэглэж байсан ан агнуурын соёлыг халж, амьтныг гаршуулж гэршүүлэн дасгаснаар малын мах сүүг боловсруулан хүнсний хэрэгцээгээ хангах болсон мал ахуйн соёлын дэвшлийн ул мөр болно.

Хүн төрөлхтний соёлын анхдагч ололтын нэг болох галын соёл бий болсноор ангийн мах шүүсийг борлуулж идэх болсон ба улмаар шүүс идээг түүхий шүүрхий идэхийг цээрлэх, чоно нохойн шүд хүрсэн махыг цээрлэх, араатантай нэг тогооноос хооллохыг цээрлэх зэрэг нэгэн бүлэг соёлын дэвшил гарсан байдаг. Харин байгаль ертөнцийн бэлэн нөөцийг шууд хураан авч аж төрдөг, анчид- түүн цуглуулагчид (chasseurs-cueilleurs) буюу байгалийн хүмүүний (Homme de nature) [Копан 2007, 77]⁴ соёлоос мал ахуйн соёлд шилжсэнээр малын мах сүүг ангийн мах шүүстэй ойр тавихыг цээрлэх, малын хүн хээр мах идэхийг цээрлэх, малын махыг босоогоороо идэхийг цээрлэх, малын далыг шүдээрээ зулгааж идэхийг цээрлэх зэрэг олон зүйлийн цээрүүд бий болжээ.

Ан агнуурын соёлоос мал ахуйн соёлд шилжсэнээр монгол идээ ундааны соёлд гарсан гол өөрчлөлтийг тусгасан цээр ёсны сонгодог нэгэн жишээ бол ангийн махнаас

⁴) Копан Ж. Угсаатан судлал, хүн судлалын удиртгал. Франц хэлнээс орчуулсан С.Дулам, хянан тохиолдуулсан Т.Төмөрхүлэг, Д.Бум-Очир, Улаанбаатар, 2007.

айраг цагаа бузартаж гэмтэх тухай ойлголт юм. Жишээлбэл, монголчуудын дунд нийдэм байдаг нэгэн цээр бол “... идээ цагааны гэрт ангийн мах оруулж болохгүй, айраг исэхээ болино, архи гарахаа болино...”⁵ хэмээх буюу “луу зүг цагаан идээний орлогын зүг тул улаан мах өлгөдөггүй”⁶ зэрэг жишээ байна. Энд нэрлэж буй “айраг гэмтэх”, “архи сархад гарахаа болино” хэмээн ангийн махнаас цэрвэн сэжиглэх энэхүү үзэл ойлголт нь бидний бодлоор ан агнуурын улирламал соёлоос татгалзаж, мал аж ахуйн гол ололт дэвшил болох сүү тэргүүтэн идээ ундааг хүндэтгэн эрхэмлэх болсон соёл сэтгэлгээний илрэл төдийгүй хээрийн соёлоос гэрийн соёлд дэвшсэн түүхэн ололтоо дурсан тэмдэглэсэн соёлын код мөн болно.

Монголчуудын таван өнгө идээ ундааны соёлоос энэ удаад улаан идээ буюу шүүс идээний соёл дахь ариун бузрын тухай цээр ёсыг судлаад дараах дүгнэлтийг хийж байна.

1. Монголчуудын шүүс идээний цээр болоод эртний домгууд нь ан агнуураас мал аж ахуйд, хээрийн соёлоос гэрийн соёлд дэвшсэн соёлын түүхэн ололтыг зан үйл бэлгэдлийн аргаар кодлон хадгалсан соёл шүтлэгийн нийлэг ойлголт болно.

2. Монголчууд энэ ертөнцийн мөчтөн амьтдаас хүний мах иддэг юм уу, эсвэл амьтны зүйлийн үүслийн хувьдаа заримдаг шинжтэй, эвэр туруугүй мал амьтны махыг бузар тул идэж болохгүй, харин эвэр туруутэй, өвсөн тэжээлт амьтны мах бол ариун чанартай тул идэхэд цээргүй гэсэн шүүс идээний соёлын ангиллыг бүтээжээ. Иймээс мал амьтны махыг хүнсэнд хэрэглэхдээ үхэр хонь зэрэг туруутай, хэвэгч мал амьтны махыг идэхэд цээргүй ба харин эдгээр шинж заримдаг тэмээ зэрэг мал амьтны махыг идэж болохгүй хэмээн цээрлэдэг байна.

3. Амьтны зүйлийн хувьд заримдаг шинжтэй, эсвэл эвэр туруугүй мал амьтны махыг бузар хэмээн цээрлэх энэхүү ёс нь монголчуудын идээ ундааны соёлд гарсан нэгэн томоохон дэвшил мөн бөгөөд зүйлийн үүслийн талаарх эртний ой дурсамж хийгээд цус ойртолтын аюулаас болгоомжлох айдсыг хадгалж байна.

НОМ ЗҮЙ

1. Аман хууль, (2000). Цуглуулан эмхтгэж, удиртгал бичсэн Л.Түдэв. Улаанбаатар,
2. Бум-Очир Д, Мөнх-эрдэнэ Г. (2012). Нийгэм соёлын хүн судлалын онолын үүд. Редактор С.Дулам, Г.Баттогтох, МУИС, Нийгэм соёлын антропологийн тэнхим. Улаанбаатар,
3. Дулам С, (1989) (2009). Монгол домог зүйн дүр. 2 дахь хэвлэл, Ариутган шүүсэн Д.Бум-очир, МУИС., НСИСТ., ОУМСТ. Улаанбаатар,
4. Копан Ж, (2007). Угсаатан судлал, хүн судлалын удиртгал. Франц хэлнээс орчуулсан С.Дулам, хянан тохиолдуулсан Т.Төмөрхүлэг, Д.Бум-Очир, Улаанбаатар,
5. Монгол ардын домог үлгэр. (1989). Эмхтгэсэн Д.Цэрэнсодном. Редактор Х.Сампилдэндэв, Ц.Шүгэр, ШУА ХЗХ., Улаанбаатар,
6. Durkheim, E. (1968). The Elementary Forms of Religious Life. J. Swain. trans. New York: Free Press.

⁵ Энэхүү жишээг 1994 онд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ард 61 настай, Олхонуд овогтой, Цэвэгжавын Лонжидоос Г.Нандинбилиг тэмдэглэн авав.

⁶ Мөн адил.

7. Douglas, Mary. (1963).The Lele of the Kasai (Касайгийн Леле) International African Institute.
8. Douglas, Mary. (1966). Purity and Danger: An Analysis of concepts of pollution and taboo. Routledge.
9. Douglas, Mary.(1970).Natural Symbols: Explorations in Cosmology Barrie and Rockliff.

SUMMARY

Following summary is concerned on the taboo concept of purity and dirt in red food, meat meal culture, which is one of the Mongolian five colored meal culture.

1. Mongol taboo related with meats is a common concept of culture and religious, which has been conserved by symbolizing cultural achievements on the shift from hunting culture to livestock culture (from field culture to home culture).

2. Initial criteria of taboo of purity and dirt in meals is animal identity differing from human characteristics like horn, hooves, etc. According to Mongols' taboo of meals, the cloven-hoofed ruminant as the model of pure class of animal for the habitat, and other animals with deviant feet like camel. It appears that this phenomenon is identical with biblical term 'clean'. As the Mongol myth would consider some species as hybrid animals, which meant that it is prohibited to use those animal for food.

3. The taboo to prohibit to eat the hybrid animals because of their anatomy is an achievement of meal culture and it illustrates both an ancient knowledge about the origin of species and an ancient fear of genetic abnormal alternation due to marrying to relatives.